

БОГИНО ХУГАЦААНЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛ (С 1)

ОЛГОХ ХҮРЭЭ:

- Монгол улсын сонин хэвлэл, телевиз радио, сэтгүүл бусад хэвлэл мэдээллийн байгууллагаас томилогдон богино хугацааны сурвалжлаг хийх, мэдээлэл дамжуулах иргэн
- Гадаадын мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу богино хугацаагаар томилогдон сурвалжлаг хийх, мэдээлэл дамжуулах иргэн
- Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын охин компанийг байгуулах, бэлтгэл ажлыг хангах зорилгоор богино хугацаагаар ажиллах иргэн

Энэхүү ангиллын визээр Монгол Улсаас БНСУ-д зорчихыг хүсэж буй иргэн бүр **Солонгосын Виз Мэдүүлгийн Төвөөр** дамжуулан виз мэдүүлнэ. Та 3 сар хүртэлх хугацаатай 90 хоногийн нэг удаагийн нэвтрэх виз эсхүл 6 сар хүртэлх хугацаатай 90 хоногийн хоёр удаагийн нэвтрэх виз мэдүүлж болохыг анхаарна уу. (Хоёр удаагийн нэвтрэх буюу дабль виз мэдүүлэх тохиолдолд 2 удаа зорчих шалтгаанаа нотлох шаардлагатай). БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримт шаардах боломжтой. Виз мэдүүлгийн бичиг баримтууд нь эх хувь эсхүл хуулбар байна.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (өнгөт цээж зураг 3.5 x 4.5 см хэмжээтэй нэг хувь, сүүлийн 6 сарын дотор авахуулсан)
2. Гадаад паспорт, хуулбарын хамт
3. Гэрлэлтийн лавлагаа
 - Насанд хүрээгүй хүүхэд (19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа (эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбар хавсаргах)
4. Томилолтын бичиг
5. Ажлын газрын тодорхойлолт эсвэл сурвалжлагчийн үнэмлэх (Гадаад мэдээ дамжуулах сурвалжлагчийн үнэмлэх)
6. ААН-ийн гэрчилгээний хуулбар